



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2015 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/59

Улаанбаатар хот

Г
**Техникийн хяналтын үзлэгийн явуулын төвийг
ажиллуулах тухай**

Монгол улсын “Автотээврийн тухай” хуулийн 17.1 дэх заалт, Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 232 дугаар тушаалаар баталсан “Техникийн хяналтын үзлэг хийх журам”-ын 1.2, тус үндэсний төвийн дүрмийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн хяналтын үзлэгийн суурин төв нь эрчим хүч тасрах, автозамын барилга угсралтын үеэр зам, талбай хаагдах, техникийн эвдрэл, саатал гарах гэх мэт хүчин зүйлсийн нөлөөгөөр үйл ажиллагаа тасалдах үед үйлчилгээг явуулын хэлбэрээр түр хугацаагаар үргэлжлүүлэн зохион байгуулахыг техникийн хяналтын үзлэгийн төвийн дарга наарт үүрэг болгосугай.

2. Энэ тушаалыг таниулан сурталчилж, мөрдөж ажиллахыг Техникийн хяналтын газар /Б.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Техникийн хяналт, бүртгэл хариуцсан дэд захирал /Т.Баягсалан/-д даалгасугай.



ЗАХИРАЛ Н.ПУНЦАГ